



Б.Өлзийсайхан
МУБИС-ийн НХУС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн багш, магистр

ХЭЛНИЙ ШИНЖ ЧАНАРААС ХАМААРАХ ХҮНИЙ ОРШИХУЙ

Хэл бол танин мэдэх, бодит байдлыг илэрхийлэх хэрэгсэл төдий биш, харин мэдэгдэхгүй байгаа бодит байдлыг танин мэдэх хэрэгсэл мөн. В.Гумбольдт

Abstract: language is not ordinarily thought of as of essential interest to the students of social science, it powerfully conditions all our thinking about social problems and processes. Human beings do not live in the objective world alone, nor alone in the world of social activity as ordinarily understood, but are very much at the mercy of the particular language which has become the medium of expression for their society. The fact of the matter is that the "real world" is to a large extent unconsciously built up on the language habits of the group. No two languages are ever sufficiently similar to be considered as representing the same social reality. The worlds in which different societies live are distinct worlds, not merely the same world with different labels attached.

Language is becoming increasingly valuable as a guide to the scientific study of a given culture. In a sense, the network of cultural patterns of a civilization is indexed in the language which expresses that civilization. It is an illusion to think that we can understand the significant outlines of a culture through sheer observation and without the guide of the linguistic symbolism which makes these outlines significant and intelligible to society.

Key words: language and real world, language objectivity, human beings, logical semantics, language symbols, linguistic relativity theory

XX зуунаас хойших философийн олон хандлага хүний оршихуй, хэл, үнэлэмжийн тухай асуудлыг онцлон судлагдахуунаа болгож ирсэн ба "экзистенци", "феномен", "утга ба утгат чанар", "хэлэн тоглоом", "ойлгохуй", "үнэлэмж", "бүтэцчилэх арга" гэх мэт олон ойлголтыг боловсруулжээ. Тэдгээр философи хандлагын нийтлэг шинж нь хэлний асуудалтай холбоотой хөгжиж ирсэнд байгаа юм. Герменевтик философичид ямар ч үзэгдэл

хэлэнд илэрхийлэгдэх боломжтой бөгөөд аливаа ойлгохуй нь хэлнээс хамаарч, хэлэхүйд хэрэгждэг хэмээн үзэж байв. Тухайлбал, М.Хайдеггер ахуйн тухай асуудлыг хэлний тухай асуудалтай холбохдоо "үгийн язгуур утга, агуулга нийгмийн бодит харилцааны илэрхийлэл болдог ба хэл нь ахуйн орон гэр болох хувьдаа ахуйд хүрэх замыг нээдэг"¹ гэж дүгнэсэн бол, Х.Г.Гадамер "үнэндээ бид ярьдаг хүмүүс, өөр хэн ч биш. Тиймээс хүний ахуй бол яригч ахуй юм" гээд хүн өөрийн оршихуйг зөвхөн хэлний тусламжтайгаар ойлгодог, хүний оршихуйг "үгэнд оршигч" гэж тодорхойлсон байна. Харин структуралист (бүтэцчилэх) аргыг үндэслэгч К.Леви Строс бүтцийн тухай асуудалд хэлний үүднээс хандсан билээ. Хэл бол гэрлэх ёс журам, төрөл төрөгсдийн нэр дуудлага, зан үйл, янз бүрийн баг, домог үлгэр зэрэг олон хэв маягтай бөгөөд хэлний агуулгыг задлах, харилцан бие биед нь шилжүүлэх, нэгийг нь нөгөөгөөр орлуулах замаар нийгэм, соёлын тодорхой үзэгдлийн бүтцийг тайлбарлах хэрэгтэй. К.Леви Строс "бодгаль хүн (индивид) хэлний тусламжтайгаар бүлгийнхээ соёлыг олж авдаг ба соёл ямар хэмжээнд хэлнийхтэй төстэй бүтэцтэй байна, хэл тэр хэмжээнд соёлын нөхцөл болдог" гэж үзжээ. Энэхүү өгүүлэлд хүний ахуйн суурь нөхцөлүүд болон хэлбэрүүдтэй холбогдох хэлний дотоод холбоо, соёл-түүхэн дэх хэлний бэлгэдэлт шинж, объектив утга ба утгат чанар, хэл шинжлэл болон шинжлэх ухааны бусад салбар хоорондын хамтын ажиллагааны ач холбогдлыг өгүүлэх юм.

Субъектээр хэрэгжин биежиж буй яриа хэлэхүйн, дуугарч буй орон зайн идэвхтэй хуваарилалт байдалтай хэл нь субъектээр илэрч буй материалын онцлогийг өөрийнхөө өвөрмөц байдалд барьж авдаг. Өөрөөр хэлбэл, хэл нь ахуйн утган зураглал төдийгүй, бас ертөнцийн өөрийнх нь "аялгыг" дуу авиа, зогсоц болон өргөлт аялгаар

¹ Чимэг О. М.Хайдеггерийн философи дахь ахуйн үнэн ба "ахуйн орон гэр болох хэлний" тухай үзэл санааны эх сурвалж. Эрх чөлөө ба философи ҮИ, УБ.,2000. х.26

илэрхийлдэг мэдрэмжлэг зураглал болдог. Тийм учраас сэтгэлгээг илэрхийлэх хэрэгсэл, ертөнцийг хүртэн мэдрэх хэрэгсэл, түүнийг таних рациональ утгат хэлбэрүүдийг бодвол хэл гайхамшигтай их ач холбогдолтой билээ.

Хэл хэдийгээр бүтэц байгууламжийнхаа түгээмэл уян хатан чанараар аливаа формаль хэлбэрийг барьж авдаг шигээ аливаа мэдрэмжийг барьж авч, бас илэрхийлэх чадвартай ч, П.А.Флоренский² хэлний хэлбэрт төдийгүй, басхүү түүний материд нь, өөрөөр хэлбэл, үг болон түүний хэлэгдэх дуудлагад анхаарал хандуулжээ.³ Хэлний материйн язгуур байгалилаг шинжүүд нь хүний субъектив утгат амьдралыг тээгчид юм. Тийм ч учраас, энэ утгаараа үг шинжүүд хүний биеийн байгалилаг шинжүүдтэй адилсдаг. Эдгээр шинжийн аль аль нь нэгэн ижил чиг үүргийг хэрэгжүүлэх аж. Тухайлбал, дуугарах үйл (дуу авиа гаргах явдал) нь бодгалиудын байгалилаг биет ахуйн үргэлжлэл юм. Ялгаа бүхий дуу авиа нь субъектив агуулгыг тэмдэглэгч хэлбэр бөгөөд бодгалиудын ахуйг зохион байгуулагч эгшин болдог. Энэхүү ахуйг бүхэллэг байдал руу холбогч хэлбэр болдог амьтны тэрхүү ертөнцөд идэвхтэйгээр нөхөн үйлдвэрлэгдэх хэлбэртэй буй биет зохион байгуулалт нь энэ ертөнцийн, энэ ахуйн орон зайн тодорхойлолтуудтай тохирч байна. Энд биеийн эрхтнүүдийн чиг үүрэг нь дуу авиа, өнгө, үнэр, мэдрэх хүртэх чадамж, хөдөлгөөн ба төрх маягийн материд шингэснээр ахуйн ерөнхий орон зайг үүсгэнэ. П.А.Флоренский энэхүү ердийн байгалилаг ахуйг хүний оршихуйд ч байлгаж үздэг. Ийм учраас ертөнц нь зөвхөн хүний хэлээр төдийгүй, басхүү анхаарал хандуулж буй амьтны ахуйд ч дурын хэлбэрээрээ, дурын илрэлээрээ “дуугарч” байна.⁴

Үүний улмаас л хүний биет шинж нь биеийн орон зайн тодорхойлолтуудын хүрэнээс гарч, бодит ахуйн орон зай руу хүрснээр “бодит амьдралын хэл” нь түүхэн явцад ёс суртахуун-гоо сайхны агуулгаар, үнэлэмжээр дүүрсэн субъектив шинжтэй сэтгэцийн маш нарийн хэлбэрүүд болтлоо дүрс хувирдаг.

Арга хэрэгсэл нь дам болгож буй зүйлийнхээ түгээмэл дүр төсөөллийг өөртөө барьж байдаг. Тийм болохоор тэрээр зөвхөн өөрийгөө, өөртөө буй өөрийн ахуйг төдийгүй, улмаар харьцаж буй зүйлийнхээ ахуйг ч, бас чухамхүү өөрийнхөө дам болгож байгаа үйл явцын дотоод идэвхт уг чанарыг ч зааж байдаг. Жишээлбэл, сүхэнд сүхийг олж харна гэдэг бол сүхээр дам шинжтэй болсон үйл ажиллагааны схемийг (бүдүүвчийг) дэлгэнэ гэсэн утгатай. Амьтны хүртэн мэдрэхүйд сүх бол сүх биш, харин тэр бол ямар байх нь

² Флоренский П.А.(1882-1937) хэлний болон оюун санааны хэлбэрүүд нь адилсах зарчмаар хүний мэдрэгдэгч ба ухамсарлагдагч ахуйн бүх орон зайг илэрхийлдэг гэж үздэг.

³ Лобастов Г.В. Язык: смысл и генезис. (Орч. Ж.Отгонбаяр) Вопросы философии, 2011. №5. с.53

⁴ Мөн тэнд., с.53

хамаагүй ямар нэгэн өөртөө байгаа ахуй юм. Иймд үгийн утгат чанар бол денотат, юмсыг тэмдэглэж заасан ахуй биш, тэгэхээр түүний утгын холбогдол нь тодорхой олонлогийг онцлон ялгаж тогтооход, улмаар үгийг ухаарахад хангалттай тийм тодорхойлолтуудын нийлбэртэй тэнцүү биш юм.⁵ Логик семантик нь иймэрхүү чиг хандлагыг илэрхийлдэг. Логик семантик үзэл баримтлалд (Рассел, Карнап, эхэн үеийн Витгенштейн) мэдээллийг томъёолох буюу хүртэх хүний чадвараас хамаарахгүйгээр мэдээлэл дамжуулах хэл ярианы чадварт илүү анхаардаг. Л.Витгенштейн бол яг бихевиорист биш боловч түүний анхан үеийн ба хожмын аль аль үеийн философи сургаалын үндэс нь бихевиорист арга зүй болж байв.⁶ Ухамсар бол субъектын бие даасан, санаалаг ертөнц мөн гэдэг баримтлалыг бихевиоризм эрс үгүйсгэж, ухамсрыг амьтдын авир үйлдэлтэй адилтгадаг билээ. Тухайлбал, ухамсрыг орлогч авир үйлдэл нь гадаад, дотоод түлхээсэнд (стимулд) организм хөдөлгөөн, үг, догдлол зэргээр үзүүлдэг хариу үйлдлүүдийн тогтолцоо мөн. Сэтгэцийн үйл явц нь хөдөлгөөний идэвхээс хамаардаг ба нүдний булчингийн хөдөлгөөнөөс харааны хүртэхүй, биеийн өөрчлөлтөөс догдлол, ярианы эрхтнээс сэтгэхүй хамаардаг гэж үздэг.

Авир үйлдлийн тухай дээрх хандлагын эх сурвалж нь Оросын эрдэмтдийн боловсруулсан рефлексийн онол боловч бихевиоризмыг рефлексийн онолын үргэлжлэл гэж ойлгож болохгүй билээ. Болзолт рефлекс бол хүрээлэн буй орчны талаарх анхны мэдлэгийн цуглуулга ба шинэ цочоогуур бүр баримжаалах рефлексийг үүсгэдэг. Рефлекс нь хэлний тусламжтайгаар бидэнд тасралтгүй үүсэх болсон нь хүн амьтадтай адил аль нэг үзэгдэлтэй тухай бүр өөрөө танилцаж учирч байх шаардлагагүй болсон юм. Хэл нь хүрээлэн буй ертөнцийг баримжаалахад шаардлагатай хугацааг маш их товчилж өгсөн ба болзолт рефлексийг жолоодох зам нээгдсэнээр хүний байгалиас хамаарах байдал улам бүр багассаар байна.

Хэл нь “үг-юм” гэсэн харилцааг тодорхойлох явдлаар дамжин эзэмшигддэггүй байна. Хараа, сонсголгүй хүүхдүүдийн бие хүний төлөвшлийг задлан шинжилснээр Э.В.Ильенков (1924-1979) дараах дүгнэлтэд хүрчээ: “Дохионы хоёрдугаар систем болох хэл заншиж дадал болохоос зөрүүдлэн байлаа. Хараа, сонсгол, хэлгүй хүүхэд нь багш нарын зүгээс юмс ба “тэмдэг” хоорондын “болзмол холбоо”-г түүнд итгүүлж бий болгох гэсэн бүх уйгагүй оролдлогод дургүйлхэн, уг системийг амин чухал байдлаар хүлээн аваагүй юм. “Тэмдэг” ба өөрөөр нь “тэмдэглэж буй” юмтай холбогдох цорын ганц болзмол холбоо бүрэлдэж **ТОГТОХЫН ТУЛД** (үүнийг ойлгуулахын тулд) найман

⁵ Мөн тэнд., с.54

⁶ Гомбосүрэн Ц. Хэлний философи ба хэл шинжлэлийн (лингвистик) философи, Уб.,2010. х.147



мянган шаргуу үйлдэл шаардлагатайг туршлага нотлон харуулсан”.

Үгсийн сангийнх нь нөөцийг эзэмших замаар гадаад хэл судалж байгаа хүн уг хэлийг хэзээ ч танин мэдэж, ойлгож чадахгүй ажээ. Хэлний аливаа элементийг утгат агуулгад нь, улмаар гагцхүү хэлний материйн бүхэллэг хөдөлгөөн дэх чиг үүрэгт нь л ойлгож болно.⁷ Энэ бол хэсэг нь гагцхүү бүхлээс л ойлгогддогийн адил юм. Хэсэг нь ингэж ойлгогдохдоо хэсгийнхээ байр байдалд, бас өөрийнхөө өвөрмөц үүрэгт буй бүхлийн хэсэг байдлаар ойлгогдоно. Тиймээс хэлэн дэх дээд нарийн шириин зүйлийг хэсэг бусаг бүрдлүүдээр танин мэдэж болохгүй. Учир нь үг гагцхүү хэлэхүйн (хэл ярианы) бүрэлдэхүүнд л ойлгомжтой буюу мэдрэгдэм болдог. Тиймээс үг бүрэн утгаа гагцхүү хэлэхүйн бүтцэд л олж авна хэмээн В.Гумбольдт үзсэн юм.

Сэтгэхүй хэлээр дам шинжтэй болж буй байдал нь бүх талаар уян хатан байх шаардлагыг хэлэнд тулгадаг билээ. Хэлний логикт ч логик байх нь мэдээж хэрэг. Гэхдээ энэ бол хэлзүй хэмээх өвөрмөц логик юм. Э.В.Ильенковын бичсэнээр, “Гагцхүү хэлний өвөрмөц материд илт хамаарч буй хэлбэрүүд, ямар ч байлаа гэсэн, хэлэнд бас түүний бодит үйлдэлд (аман болоод бичгийн хэл ярианд) оршин байдаг нь дурын хэл шинжлэлийн хувьд илэрхий байдаг. Чухамдаа эдгээр хэлбэр өөрсдөд нь илэрхийлэгдэж буй тэрхүү “агуулгын” хөдөлгөөнөөс, өөрөөр хэлбэл, утга ба утгат чанарын хөдөлгөөнөөс гаргалгаа болохгүй. Эс тэгвэл, яагаад нэг хэлэнд дөнгөж дөрөвхөн тийн ялгал байхад нөгөөд нь хорин найман тийн ялгал байгаа нь ойлгомжгүй байх болно. Тийн ялгал бол хэлний илт хэлбэр мөн, харин сэтгэхүйн, ядаж л гэхэд “үгэн” сэтгэлгээний шууд шулуун хэлбэр биш...”⁸.

Хэл бол сэтгэхүүд бодит байдлын аливаа агуулгыг илэрхийлэх түгээмэл арга хэрэгсэл болдог. Үйл ажиллагаандаа сэтгэлгээг тогтоон баригч ямар ч биет-практик арга хэрэгсэл тийм даяар түгээмэл чанаргүй юм. Сэтгэлгээний биет ахуй (юмжсан ойлголт) мөн чанартаа гагцхүү өөртэйгөө тэнцүү агуулга болж байдаг. Хэл (үгийн жинхэнэ утгаар) нь чухамдаа энэхүү зөрчлийн нөхцөл байдалд, энэ зөрчлийг шийдвэрлэх арга хэрэгсэл байдлаар үүсдэг байна. Бодит амьдралын хэлээр ярихын тулд матери нь энэхүү амьдралтай ямар ч нийтлэг, адилсалгүй тийм хэл зайлшгүй шаардлагатай. Учир нь биет арга хэрэгсэл нь зөвхөн онцгой түгээмэл ерөнхий байдлыг, чухамхүү энэ арга хэрэгслийн хөдөлгөөний түгээмэл хэлбэрийг илэрхийлж чаддаг. Түүний бүдүүвчлэн илэрхийлэх чадварын хязгаар ч, мөн өөр ямар нэгэн зүйл (санаан хэлбэрийг тогтоон барих үйл) агуулгынхаа хэмжээнд төсөөлөгдөж,

төлөөлөгдөх боломж ч багтсан байна. Төсөөлөгдөж, төлөөлөгдөж буй зүйл нь төсөөлж буй этгээдийн боломжуудтай зайлшгүй харьцмал байна.⁹ Дохио зангааны хэл нь болзмол чанарыг хамгаас бага агуулдаг. Иймээс тэдгээрийн янз бүрийн хэлбэр нь хялбар хөрвөдөг (орчуулагддаг), өөрөөр хэлбэл, бодит байдал өөрийнх нь утгын тал, агуулгаараа ойлгогдож эзэмшигдсэн тэр үед тийнхүү хялбар юм. Гэтэл үнэндээ бодит байдлын өвөрмөц агуулга руу ийнхүү татагдаж, хандсан байдал нь сэтгэхүйн хөдөлгөөний дотоод хязгаарлалт болж таардаг ба энэхүү хязгаарлалт нь уг чанартаа хүний үйл ажиллагааны даяар түгээмэл санаалаг хэлбэр болдог. Хэл дохио зангаа нь хэлбэрийнхээ хүрээнээс гарснаар, өөрөөр хэлбэл, хэлний матери хамгийн уян хатан бөгөөд түгээмэл шинжтэй байдаг тэр талбар руу гарч очсоноор энэхүү зөрчил нь шийдвэрлэгддэг. Тэгэхлээр хэрэв “материтай зууралдсан байх хараал” (К.Маркс) анхнаасаа л оюун санаанд тусаагүй бол тийм хөдөлгөөний хязгаар нь утган агуулгыг дамжуулах үед аливаа материаллаг байдлыг хуулбарлан үгүй хийхэд орших байсан. Хэрэв хэлний материд үнэмлэхүй зайлшгүй шинж байдаг юм бол түүнд зөвхөн ганц шаардлага тавигдана, энэ бол утгыг тогтоон барьж, тэгэхдээ түүнийг гажуудуулж, эвдэхгүй байх явдал юм. Гэтэл энэ нь юм ба хэлний агуулга дахь ерөнхий, адил эгшин, зүйлийг үгүй хийх нөхцөлд л гагцхүү бололцоотой. Тийм учраас хэлний матери нь биет ертөнцийн материтай ямар ч адилсалгүй байдаг. Чухам энэ шалтгааны улмаас л хэлний матери нь юмсын ертөнцийн аливаа хэлбэрийг илэрхийлэх чадвартай.

Хэлэн дэх утга ба матери бол сэтгэхүйг ч, хэлийг ч өөртөө бий болгож, улмаар аль алиныг нь хэрэгцээтэйгээ уялдуулж тохируулан хэлбэршүүлж байгаа хүний жинхэнэ бодит байдлын хөдөлгөөнд өөр хоорондоо зайлшгүй байдлаар холбогдсон шууд эсрэгцлүүд юм. Хүний ахуйн янз бүрийн хүрээний өвөрмөц “хэлүүд” үүсдэг, бас хөгждөг, хэлнийхтэй төстэй (олон тохиолдолд “хэл” хэмээн нэрлэдэг өнгө будгийн хэл, дуу авианы хэл гэх мэт) чиг үүргийг тээдэг арга хэрэгслүүдийн янз бүрийн тогтолцоо үүсэж, хөгжих хэрэгцээ байна. Харин утга ба хүний үйл ажиллагаан дахь хэлэн материйн эсрэгцлүүд нь адил юм. Тэгээд ч энэхүү үйл ажиллагаагаар өөрөөр нь адилсдаг. Ийм учраас хэлний (хэлний материйн) хөдөлгөөнд бид материйг олж харахгүйгээр утгуудын хөдөлгөөнийг олж хардаг. Хэлний хөдөлгөөнөөр утга төрдөг, утгын хөдөлгөөн нь хэлний хөдөлгөөнийг, жишээ нь, үгийг, найруулга зүйг гэх мэтээр төрүүлдэг. Тэр ч байтугай “дуу авианы бодгаль хэлбэрийг” ч утгын хөдөлгөөн төрүүлнэ. Л.С.Выготский “сэтгэлгээ үгэнд төрдөг, сэтгэлгээ үгтэй хамт төрдөг. Үг нь сэтгэлгээг үүсгэдэг, үгийн өөрчлөлт нь сэтгэлгээг

⁷ Лобастов Г.В. Язык: смысл и генезис. (Орч. Ж.Отгонбаяр) Вопросы философии. 2011. №5. с.54

⁸ Мөн тэнд., с.54-55

⁹ Мөн тэнд., с.55

өөрчилдөг”¹⁰ гэжээ.

Өнөөдөр эрдэмтэд хэл шинжлэл болон шинжлэх ухааны бусад салбар хоорондын хамтын ажиллагаанд илүүтэй анхаарал хандуулж байна. Хэл шинжлэлийн судалгаа соёлын түүх болон хүн судлалд чухал ач холбогдолтой нь хэдийнээ тодорхой болов. Хэл шинжлэлийн судалгааны хөгжлийн явцад хэл нь хүний тухай шинжлэх ухаануудын танин мэдэхүйн зэмсэг гэдэг утгаар ашиг тустай байдлаа улам ч их нотолсоор байна. В.Гумбольдт ба Л.Витгенштейн нарын бүтээлүүдээр бэлтгэгдсэн “Хэл шинжлэлийн харьцангуй онол”-ыг¹¹ үндэслэгч Америкийн хэл шинжлэгч Э.Сепир¹² (1884-1939) “Хэл шинжлэгч хүн хэл шинжлэлийг соёлын түүх болон антропологи, социологи, психологи, философитой, ялангуяа ойрын ирээдүйд физиологи, физиктэй холбож өгөх шаардлагатай ба эдгээр салбарын хамтын ажиллагааны ашиг тус, ач холбогдлыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Өөрсдийнхөө сэтгэлд хамгийн ойр байдаг судалгааны үндсэн судлагдахууны загварын хүрэнээсээ гарч чаддаггүй хэмээн байнга буруутгагдаж байдаг хэл шинжлэгчид нь тэдний шинжлэх ухаан хүний үйл хөдлөлийг бүхэлд нь тайлбарлахад ямар ач холбогдолтой байж болохыг ухамсарлах ёстой ба тэд хүссэн хүсээгүй хэлний салбарт түрэн орж ирж байгаа антропологи, социологи, физиологийн асуудлууд дээр улам их ажиллах шаардлагатай болно”¹³ гэж үзжээ.

Хэл нь соёлын талаарх шинжлэх ухааны судалгаанд удирдан тэргүүлэгч эх, эхлэл гэдэг утгаараа ихээхэн ач холбогдолтой болсон билээ. Аливаа иргэншлийн мөн чанар болсон соёлын ёс заншлын систем нь тухайн соёл иргэншлийг илэрхийлдэг хэлний тусламжтайгаар эмхлэгдэн цэгцлэгддэг байна. Баримжаалагч болох хэлний бэлгэдэлгүйгээр цэвэр ажиглалтын үндсэн дээр аль нэг соёлын үндсэн зарчмуудыг ойлгох боломжгүй. Хэлний бэлгэдэл нь л эдгээр зарчмыг нийгэмдээ ач холбогдолтой, ойлгомжтой болгож өгдөг байна. Тухайн нийгмийнх нь

¹⁰ Мөн тэнд., с.55

¹¹ Э.Сепир (1884-1939) болон түүний шавь Б.Л.Уорф (1897-1941) нар олон үзэгдлийн анхдагч шалтгааныг хэлнээс олж хардаг ба хүний авир үйлдэл, хүрээлэн буй орчны тухай мэдрэхүй, сэтгэхүйн төсөөлөлд хэл болгон өөр өөр дүр төрх, залруулга, засварыг оруулж байдаг гэж үздэг.

¹² Эдуард Сепир Германд төрсөн ба 1889 онд АНУ-д очсон байна. Тэрээр хүн судлал, хэл шинжлэлийн үүднээс Америкийн Индианчуудын хэл ба соёлыг судалсан. Мөн хэл шинжлэлийн авиа зүйн асуудлаар судалгаа хийсэн анхдагч судлаачдын нэг юм. “Хэлний судалгааны удиртгал” хэмээх 1921 онд хэвлүүлсэн ном нь түүний хамгийн алдартай ном билээ. Тэрээр 1933 онд Америкийн хэл шинжлэлийн нийгэмлэгийн, 1938 онд Америкийн антропологийн холбооны ерөнхийлөгчөөр ажилласан ба Америкийн философийн нийгэмлэг, Үндэсний шинжлэх ухааны академийн гишүүн байсан.

¹³ Edward Sapir. The Status of Linguistics as a Science. Landmarks of American language and linguistics. Volume 1. Washington., 1993. p.10

хэлний өгөгдлүүдийг татан оролцуулалгүйгээр эртний соёлыг судлах оролдлого хийх нь амжилтад хүргэхгүй бөгөөд энэ нь яг л тухайн соёл иргэншлийн жинхэнэ эх баримт бичгүүдийг судалгаандаа ашиглан тайлбарлаж чадахгүй байгаа түүхчийн хөдөлмөр, туурвилтай ижил юм.¹⁴

Э.Сепир “Хэл бол нийгмийн бодит байдал дахь луужин боловч хэлийг нийгэм судлалд онцгой ач холбогдолтой зүйл гэж үзэхгүй байна. Гэтэл хэл нь нийгмийн үйл явц болон тодорхой асуудлуудын талаарх бидний ойлголт, төсөөлөлд ихээхэн нөлөө үзүүлдэг. Бидний бодож хэвшсэн шиг хүмүүс зөвхөн материаллаг ертөнц, зөвхөн нийгмийн ертөнцөд амьдардаггүй: тэд бүгд л тухайн нийгэмд өөрийгөө илэрхийлэх хэрэгсэл болсон тодорхой нэгэн хэлнийхээ эрхшээлд амьдарч байдаг” гэжээ. Өнөө үед хүн гадаад ертөнцөд үндсэндээ хэлний туслалцаагүйгээр чиг баримжаагаа олж, мөн хэл бол харилцаа болон сэтгэхүйн онцлог зорилтуудыг биелүүлэх тохиолдлын хэрэгсэл төдий байдаг гэсэн хандлагыг үгүйсгэх болов. Э.Сепирийнхээр бодит ертөнц нь аль нэг нийгмийн бүлэглэлийн хэлний тогтсон хэвшил, заншил дээр хар аяндаа бүтээгддэг. Хоёр өөр хэл нь тухайн бодит байдлыг хэзээ ч ижилхэн илэрхийлдэггүй. Өөр өөр нийгэм оршин тогтнодог ертөнцүүд бол янз бүрийн хаяг, шошго зүүсэн нэг л ертөнц биш, харин өөр өөр ертөнц юм. Жишээлбэл, энгийн нэг шүлгийг ойлгоно гэдэг нь түүнийг бүрдүүлж буй үг бүрийн ердийн утгыг л ойлгоно гэсэн үг биш. Үгээр тусгагдаж, үгийн утгын өнгө аясаар нээгддэг тухайн нийгмийн бүхий л амьдралын хэв маягийг ойлгох шаардлагатай болдог. Харьцангуй энгийн хүлээн авахуйн үйлдэл ч үг хэмээн нэрлэдэг загвар байгаа эсэхээс ихээхэн хамаардаг байна. Хүрээлэн буй орчныг тайлбарлах үед бидний сонголт бидний нийгмийн хэлний хэвшил зуршлаар урьдчилан тодорхойлогддог тул бид хүрээлэн буй орчныг өөрөөр биш, харин яг байгаагаар нь хардаг ажээ. (Нэг хэлээр ярьж байгаа ард түмэн хүрээлэн буй орчныг ижилхэн хардаг.)¹⁵

Хүн төрөлхтний соёлын суурь асуудлуудыг шийдэхэд хэлний тогтолцооны тухай мэдлэг

¹⁴ Мөн тэнд., р.10

¹⁵ Edward Sapir. Selected Writings in Language, Culture, and Personality. University of California Press., 1985. p.162



болон хэлний түүхэн хөгжлийг ойлгох нь илүү чухал бөгөөд хүний нийгмийн зан үйлийн хүрээнд хийгдэж байгаа судалгаанууд нарийн, боловсронгуй болох хэрээр дээрх чиглэлийн судалгаанд хэл улам чухал болох нь батлагдсаар байна. Тухайлбал, социологичид хэл шинжлэлийн судалгаа нь социологид онолын антропологиос дутахааргүй ач холбогдолтой болохыг анзаарч, мөн сэтгэл судлаачдын зүгээс хэлний өгөгдлүүдэд улам их анхаарал хандуулах болов. Хэл яаж бусад хүчин зүйлстэй харилцан үйлчлэлд орж, үйл хөдлөлийн хандлага болон бодол санааг хүнээс хүнд дамжуулах үйл явцыг хөнгөвчилж, эсвэл хүндрүүлдэг тухай асуудал нь дээрх салбаруудын хамгийн чухал судлагдахуун боллоо. Э.Сепир хэлний баримтуудыг бэлгэдэлт үйл хөдлөлийн өвөрмөц хэлбэр гэдэг утгаар нь авч үзэх хэрэгтэй, хэл бол соёлыг ойлгох бэлгэдэлт удирдамж гэж үзээд "сэтгэл судлаачид өөрсдийгөө хэлний психофизикийн үндэс суурийн хэт явцуу хүрээгээр хязгаарлаж, хэлний бэлгэдэлт мөн чанарыг гүнзгий судалдаггүй юм шиг санагддаг. Магадгүй энэ нь тэд хүний үйл хөдлөлд бэлгэдэл суурь ач холбогдолтой болохыг хараахан хангалттай ухамсарлаж чадаагүй байгаатай холбоотой байх. Гэсэн ч хэлний хэлбэрүүд болон үйл явцуудын бэлгэдэлт мөн чанарыг судлах явдал нь сэтгэл судлал, нийгмийн шинжлэх ухааныг хамгийн ихээр хөгжүүлж чадна гэж бодогдож байна"¹⁶ гэжээ.

Ямар ч үйлдлийг нэг бол шууд утгаар цэвэр функцийн үйлдэл, нэг бол бэлгэдэлт үйлдэл, нэг бол аль алийг нь хослуулсан гэж ойлгож болно. Хэрэв би байшин дотор орох гэж хаалгыг нь түлхэж байгаа бол энэ үйлдлийн утга санаа нь өөртөө чөлөөтэй нэвтрэлтийг хангахад оршино. Гэвч хэрэв би "хаалга тогшиж" байгаа бол тогших нь надад хаалгыг шууд нээгээд өгчихгүй гэдгийг бага зэрэг эргэцүүлснээр хийж буйг илэрхийлнэ. Тогших нь ердөө л хэн нэгэн ирж надад хаалга нээж өгөх ёстой гэсэн тэмдэг мөн. Хаалга тогших гэдэг нь хаалга онгойлгох гэсэн илүү энгийн ойлголтын орлуулалт юм. Энэ бол хэлний анхан шатны зарчим билээ. Энэ утгаараа хүний олон янзын үйлдэл нь хэлний үйлдэл байдаг. Өөрөөр хэлбэл, эдгээр үйлдэл нь биднийг ямар нэг үр дүнд хүргэдгээрээ биш, харин илүү чухал үйлдэл хийх тэмдэг, дохио болж өгдөгөөрөө чухал юм. Энгийн тэмдэг дохио нь тухайн илэрхийлэгдэж буй зүйл, утга санаатайгаа тодорхой хэмжээгээр объектив төсөөтэй байдаг.¹⁷ Тухайлбал, хаалга тогших нь тэр хаалгыг онгойлгох гэсэн сэдэлтэй шууд хамааралтай байна. Зарим тэмдэг дохио нь функциональ үйлдлийнхээ товчилсон хэлбэр нь болдог. Жишээлбэл, хүнд зангидсан нударгаа үзүүлнэ гэдэг нь жинхэнээсээ зодох явдлыг товчилсон бөгөөд харьцангуй гэм хоргүй үйлдэл юм. Хэрэв нийгэмд ийм дохио зангааг

¹⁶ Мөн тэнд., р.162-163

¹⁷ Мөн тэнд., р.163-164

заналхийлэл, уур хилэнг орлуулах тодорхой арга гэж хүлээн авч эхэлбэл түүнийг шууд утгаар нь бэлгэдэл гэж тооцож болно.

Энэ төрлийн бэлгэдлүүд нь анхдагч шинжтэй юм. Учир нь гэвэл эдгээр бэлгэдэл нь илэрхийлж байгаа тухайн зүйл, утга санаатайгаа адилхан байдаг. Гэсэн ч цаг хугацааны явцад бэлгэдлийн хэлбэр танигдахгүй болтлоо өөрчлөгдөж, илэрхийлж буй ойлголттойгоо холбоотой байх тэр гадаад байдал нь гээгддэг. Тухайлбал, улаан-цагаан-цэнхэр будганд оруулсан даавуу ба Америкийн нэгдсэн улс (энэ нь өөрөө ч тодорхойлоход амаргүй ойлголт) хоёрын хооронд ямар ч гадаад холбоо байгааг олж харах боломжгүй. Иймд далбааг хоёрдогч бөгөөд холбогдох бэлгэдэл гэж нэрлэж болно. Э.Сепир хэлийг психологийн үүднээс ойлгоно гэдэг нь нийгмийн бий болгосон ийм хоёрдогч буюу холбогдох бэлгэдлүүдийн туйлын нарийн бүрдэл утга учрыг судлах явдал гэжээ. Эртний үеийн хашгираан, хувьслын явцад хүмүүсийн боловсруулсан бусад төрлийн бэлгэдлүүд нь анхандаа харилцаа, ойлголт төсөөлөл, тодорхой сэтгэл хөдлөлтэй холбоотой байсныг үгүйсгэхгүй. Гэвч үгс, тэдгээрийн хослол болон түүгээр илэрхийлж буй утгын хоорондох холбоо хамаарал одоо бол шууд харагдахаа больсон.

Э.Сепир "хэл шинжлэл бол маш нарийн, суурь шинжлэх ухаануудын нэг юм. Магадгүй ойрын ирээдүйд хэл шинжлэл, психологи хоёрын жинхэнэ үр бүтээлч нэгдэл бий болох байх. Хэл шинжлэл нь хэлбэрийн психологи баримтлалд (gestaltpsychology) ихээхэн чухал үүргийг гүйцэтгэнэ гэж таамаглаж болно. Учир нь соёлын бүх хэлбэр дотроос хэл нь өөрийн бүтцээ соёлын бүтэцчиллийн бусад аргаас нэг их хамааралгүйгээр боловсронгуй болгосоор байдаг. Иймд хэл шинжлэл бол соёлын "психологийн газар зүйг" бүхэлд нь ойлгох нэг ёсны удирдамж болох юм"¹⁸ гэж үзсэн байна. Амьдралын өдөр тутмын үйл ажиллагааны анхдагч бэлгэдэл нь олон янзын үүрэг, зан заншлаар бүдгэрсэн байдаг. Учир нь хүний үйл хөдлөл тус бүр асар олон үйлдлийн хэлбэрийн холбоонд оршдог ба бидний ихэнх нь үйлдлийнхээ хүрээ хязгаарыг тэр болгон ялгаж салгаж чаддаггүй аж. Иймд энэ асуудлаарх судалгаанд хэл шинжлэлийн үүднээс хандах нь маш чухал ач холбогдолтой, хэлний бүтэц нь өөрөө хангалттай бие даасан шинжтэй бөгөөд өөр хоорондоо нягт харилцан үйлчилдэг өөр бусад хэлний бус бүтцүүдээс бараг хамаардаггүй байна.

Э.Сепир "Философичид хэл зүйн хэлбэр, үйл явцуудыг өрөөсгөлөөр метафизикийн мөн чанарт хувирган хөрвүүлдэг байсан цаг хэдийнээ өнгөрсөн. Тэд хэлний асуудлыг ойлгохын тулд

¹⁸ Edward Sapir. The Status of Linguistics as a Science. Landmarks of American language and linguistics. Volume 1. Washington.,1993.p.12

наад зах нь өөрсдийн хэлний талаарх хандлага, дадал зуршлуудаас татгалзах хэрэгтэй. Иймд философичид логикийг хэл зүйн бэрхшээлээс чөлөөлж, мэдлэгийн бэлгэдэлт мөн чанар болон бэлгэдлийн утга, ач холбогдлыг ойлгохоор эрмэлзэхдээ хэлний үйл явцын үндсийг судлах шаардлагатай болдог. Хэл шинжээчид нь биднээс нуугдмал байгаа үгс болон хэлний нөхцөл байдлыг илүү ойлгомжтой болгодог. Хүний зан үйлийн тухай судалгаа хийдэг бүх судлаач дундаас хэл шинжээчид судалдаг зүйлийнхээ онцлогоос хамаараад өөрийн мэдрэмжийнхээ хувьд хамгийн том релятивист байж, өөрийн хэл ярианыхаа хэлбэрүүдийн нөлөөлөлд аль болох автахгүй байх хэрэгтэй” гэжээ.

Мөн хэл шинжээчид байгалийн шинжлэх ухааны төлөөлөгчдөд, үүнд ялангуяа физик, физиологийнхонд, тэдгээрийн техник хангамжтай холбоотой зүйл дээр багагүй өртэй гэж Э.Сепир үзсэн юм. Хэл шинжлэлийн гүнзгийрүүлсэн судалгаанд шаардагддаг урьдач нөхцөл болох авиа зүйг хэл ярианы эрхтнүүдийн физиологи болон акустикгүйгээр төсөөлөхөд бэрх билээ. Юуны түрүүнд нийгэмшсэн хэлний бүтцүүдийг биш, харин тодорхой нэг хүний хэл ярианы үйл хөдлөлийн бодит нарийн учир шалтгааныг сонирхдог хэл шинжээчид үргэлж байгалийн шинжлэх ухаанаас тусламж авахаар тэдгээрт ханддаг байх ёстой. Гэхдээ хэл шинжлэлийн судалгааны үр дүнд хуримтуулсан туршлага ч бас акустикийн эсвэл физиологийн хэд хэдэн зорилгод хүрэхэд ихээхэн тус болох өндөр магадлалтай байна.¹⁹ Нийгмийн үзэгдлүүдийн гадаад эмх замбараагүй байдлын ард тэдгээрийн хэлбэр, чиг хандлагын тогтмол байдал нуугдаж байдаг ажээ. Энэ тогтмол байдал нь механикийн ертөнц дэх физикийн үйл явцуудын тогтмол байдал шиг бодитой байдаг. Хэл бол юуны түрүүнд нийгэм болон соёлын хөгжлийн бүтээгдэхүүн бөгөөд хэлний тогтмол байдал болон зүй ёсны хөгжил нь мэдээж хэрэг биологийн болон психологийн урьдач нөхцөлүүд дээр үндэслэдэг. Гэвч хэлний үндсэн хэлбэрүүдийн энэхүү тогтмол байдал болон ухамсарлагддаггүй шинж чанар нь хэл шинжлэлийг биологи эсвэл биологийн жирийн нэг үр дагаварт хувиргадаггүй байна.

Сонгодог биш философийн төлөөлөгчдийн боловсруулсан холбогдох баримтлал, үндэслэлүүд нь хэлний философийн өнөөгийн төлөвийг тодорхойлж, хүний оршихуйн тухай асуудлыг хэлний тухай асуудалтай гарцаагүй холбож өгөв. Энэ хандлага нь хэлийг объектив байдлаар авч үзэн, субъектыг зөвхөн ухамсард биш, харин субъект, ухамсар хоёрыг хэлэнд хамааруулж, үнэний тухай асуудлыг утга, утгат чанарын тухай асуудлаар солих болсноор илэрч байна. Хэлний объектив

шинж чанарыг М.Хайдеггер илэрхийлэхдээ “хүн өөрөө ярьдаггүй, харин хэл хүнд ярьж өгдөг” гэсэн билээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Гомбосүрэн, Ц. (2010). *Хэлний философи ба хэл шинжлэлийн (лингвистик) философи*. Улаанбаатар
- Лэви Строс, К. (2013). *Бүтцийн антропологи*. Улаанбаатар
- Чимэг, О. (2000). М.Хайдеггерийн философи дахь ахуйн үнэн ба “ахуйн орон гэр болох хэлний” тухай үзэл санааны эх сурвалж. *Эрх чөлөө ба философи ҮI*. Улаанбаатар
- Лобастов Г, В. (2011). Язык: смысл и генезис. (Орч. Ж.Отгонбаяр) *Вопросы философии, 5*
- Edward Sapir. (1993). The Status of Linguistics as a Science. *Landmarks of American language and linguistics*. Volume 1. Washington
- Edward Sapir. (1985). *Selected Writings in Language, Culture, and Personality*. University of California Press.

¹⁹ Edward Sapir. *Selected Writings in Language, Culture, and Personality*. University of California Press., 1985. p.165-166